

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын ... –ны өдөр

Улаанбаатар  
хот

### ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь өмгөөлөгч, өмгөөлөгчдийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн байдлыг тогтоож, өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Өмгөөллийн тухай хууль тогтоомж

2.1.Өмгөөллийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Арбитрын тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Өмгөөллийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

3.1.Өмгөөллийн үйл ажиллагаанд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1-д зааснаас гадна дараахь зарчмыг баримтална:

- 3.1.1.өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох;
- 3.1.2.хүний нэр төр, алдар хүндийг хүндэтгэх;
- 3.1.3.нууц хадгалах;

3.1.4.үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн хүрээнд бүрэн, тууштай хамгаалах.

##### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."өмгөөллийн үйл ажиллагаа" гэж өмгөөлөгчийн хуульд заасны дагуу иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор тогтвортой эрхэлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажиллагааг;

4.1.2."өмгөөллийн нууц" гэж өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх явцдаа үйлчлүүлэгчийн талаар олж мэдсэн, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахуйц бүх төрлийн баримт бичиг, мэдээ, мэдээллийг;

4.1.3."үйлчлүүлэгч" гэж өмгөөллийн үйл ажиллагааны явцад өмгөөлөгчөөс хууль зүйн мэргэжлийн туслалцаа авч байгаа иргэн, хуулийн этгээдийг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ**

### **5 дугаар зүйл.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх**

5.1.Өмгөөллийн үйл ажиллагааг өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх авч өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, тангараг өргөсний үндсэн дээр эрхэлнэ.

5.2.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан дүгнэлтийг үндэслэн олгоно.

### **6 дугаар зүйл.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох**

6.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хуульч нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй.

6.2.Дараахь тохиолдолд хуульчид өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгохгүй:

6.2.1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хуульчийн эрхийг зогсоосон, хүчингүй болгосон, эсхүл түдгэлзүүлсэн;

6.2.2.өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг зогсоосон хугацаа дуусаагүй;

6.2.3.хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хязгаарласан;

6.2.4.энэ хуулийн 16.1.3-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай давхар эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа;

6.2.5.урьд өмнө санаатай гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан;

6.2.6.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18.4.1-д заасан үндэслэлээр шүүгчийг огцруулсан, Прокурорын тухай хуулийн 68.1-д заасан үндэслэлээр прокурор ажлаас халагдсан, Нотариатын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3, 18.1.6-д заасны дагуу нотариатчын нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон, Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан үндэслэлээр төрийн албан хаагч төрийн албанаас халагдснаас хойш тус тус 2 жилийн хугацаа өнгөрөөгүй;

6.2.7.Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй.

6.3.Хуульчид энэ хуулийн 6.2-т заасан үндэслэлээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгоогүй нь тухайн үндэслэл арилсан тохиолдолд дахин хүсэлт гаргах эрхийг хязгаарлахгүй.

## **7 дугаар зүйл.Мэргэшлийн хорооны дүгнэлт**

7.1.Мэргэшлийн хороо энэ хуулийн 6.2-т заасан үндэслэл байгаа эсэхийг шалгаж, хуульчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох эсэх талаар дүгнэлт гаргана.

## **8 дугаар зүйл.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох**

8.1.Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч Мэргэшлийн хорооны дүгнэлтийг үндэслэн өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэлд бүртгэж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хугацаагүй олгоно.

8.2.Энэ хуулийн 6.2-т заасан нөхцөл байдал шинээр илэрснээс бусад үндэслэлээр Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч, Мэргэшлийн хороо өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгохоос татгалзахыг хориглоно.

8.3.Хүсэлт гаргагч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгохоос татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

## **9 дүгээр зүйл.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлэх**

9.1.Доор дурдсан үндэслэлээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлнэ:

9.1.1.өмгөөлөгч өөрөө хүсэлт гаргасан;

9.1.2.багшлах, эрдэм шинжилгээ, судалгааны болон бусад бүтээлч ажил өмгөөллийн хуулийн этгээд, Хуульчдын холбоо, түүний хороодод хамаарах, цалин хөлсгүй, эсхүл ашгийн төлөө бус хуулийн этгээдэд хамаарахаас бусад ажил, албан тушаалд сонгогдсон, эсхүл томилогдсон;

9.1.3.эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас өмгөөллийн үйл ажиллагааг 6 сараас дээш хугацаагаар эрхлэх боломжгүй болсон;

9.1.4.хуульд заасан үндэслэлээр хуульчийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн;

9.1.5.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.

9.2.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхгүй бөгөөд өмгөөлөгчийн болон Өмгөөлөгчдийн холбооны гишүүний эрх эдэлж, үүрэг хүлээхгүй.

9.3.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлэх, сэргээх тухай шийдвэрийг Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч гаргана.

## **10 дугаар зүйл.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгох**

10.1.Доор дурдсан үндэслэлээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгоно:

10.1.1.өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн болох нь сүүлд тогтоогдсон;

10.1.2.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гишүүнчлэлийн хураамжийг 1 жил, түүнээс дээш хугацаагаар төлөөгүй;

10.1.3.өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгосон Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэр хүчин төгөлдөр болсон;

10.1.4.хуульчийн зөвшөөрлийг хүчингүй, эсхүл дуусгавар болсон;

10.1.5.хуулиар хориглосон ажил, албан тушаал давхар эрхэлсэн;

10.1.6.өмгөөлөгчийн үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй;

10.1.7.энэ хуулийн 9.2-т заасныг зөрчсөн;

10.1.8.өмгөөлөгч санаатай гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон;

10.1.9.энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан хариуцлагын даатгалд даатгуулах үүргээ биелүүлээгүй;

10.1.10.өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлснээс хойш 5 жилийн хугацаа өнгөрсөн.

10.2.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгох тухай шийдвэрийг Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо гаргана.

## **11 дүгээр зүйл.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх дуусгавар болох**

11.1.Доор дурдсан үндэслэлээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх дуусгавар болгоно:

11.1.1.өмгөөлөгч өөрөө хүсэлт гаргасан;

11.1.2.өмгөөлөгчийн иргэний эрх зүйн чадамжийг хязгаарласан, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

11.1.3.өмгөөлөгч нас барсан;

11.1.4.өмгөөлөгчийг сураггүй арга болсонд, эсхүл нас барсанд тооцох тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан үндэслэлээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг дуусгавар болгох, сэргээх тухай шийдвэрийг Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч гаргана.

11.3.Өмгөөлөгчдийн холбооны салбар зөвлөл энэ хуулийн 10.1, 11.1-д заасан үндэслэл илэрсэн тохиолдолд холбогдох шийдвэрийг гаргуулах тухай саналыг Өмгөөлөгчдийн холбоонд холбогдох материалын хамт ирүүлнэ.

11.4.Өмгөөлөгчдийн холбоо энэ хуулийн 11.3-т заасан материалыг хүлээн авснаас хойш 3 сарын хугацаанд уг асуудлаар шийдвэр гаргаагүй бол Холбооны салбар зөвлөл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргаж болно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**

### **12 дугаар зүйл.Өмгөөлөгч**

12.1.Өмгөөлөгч нь шүүхэд төлөөлөх, шүүн таслах ажиллагаанд оролцох, хууль зүйн мэргэжлийн туслалцааг үзүүлэх эрхтэй ~~хараат бус~~ хуульч байна.

12.2.Өмгөөлөгч нь Өмгөөлөгчдийн холбооны гишүүн байна.

### **13 дугаар зүйл.Өмгөөлөгчийн тангараг**

13.1.Хуульч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг гардан авахдаа “Өмгөөлөгч би Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ажиллахаа батлан тангараглая.” гэж тангараг өргөнө.

13.2.Өмгөөлөгчийн тангараг өргөх ёслолын журмыг Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөл батална.

13.3.Хуульч өмгөөлөгчийн тангараг өргөснөөр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх үүснэ.

### **14 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн эрх**

14.1.Хуульд өөрөөр заагүй бол өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараахь нийтлэг эрх эдэлнэ:

14.1.1.нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх, эсхүл хэрэг, маргаанд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт сэлт цуглуулах;

14.1.2.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд аль ч байгууллагад төлөөлөх;

14.1.3.үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах боломж, нөхцөлөөр хангагдах;

14.1.4.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн оролцсон ажиллагааны бусад оролцогчдод асуулт тавьж, хариулт авах;

14.1.5.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх явцад цугларсан баримт сэлт, нотлох баримттай танилцах, тэмдэглэл хийх, шаардлагатай материалыг өөрийн зардлаар хуулбарлан авах;

14.1.6.шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад нотлох баримтыг цуглуулах талаар хүсэлт тавих, нотлох баримт гаргаж өгөх, шинэ нотлох баримт шаардах буюу хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, түүнийгээ хэргийн материалд тусгуулах;

14.1.7. шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах, гарсан дүгнэлттэй танилцах;  
14.1.8. хуульд заасан үндэслэл байвал хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

14.1.9. захиргааны байгууллага, албан тушаалтан, мөрдөгч, прокурор, шүүгч, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;

14.1.10. шаардлагатай баримт материалыг бэхжүүлэх, хуулбарлан авах зорилгоор дуу, зураг, дүрс, дуу-дүрсний бичлэгийн болон бусад техник хэрэгсэл ашиглах;

14.1.11. тусгай мэдлэг шаардагдах асуудлаар мэргэжлийн байгууллага, иргэнээс өөрсдийн нь зөвшөөрснөөр, эсхүл гэрээний үндсэн дээр зөвлөгөө авах, тодорхойлолт, дүгнэлт гаргуулан авах;

14.1.12. үйлчлүүлэгч болон бусад этгээдийн хууль бус шаардлагыг биелүүлэхээс татгалзах;

14.1.13. өөрийн үзүүлсэн хууль зүйн мэргэжлийн туслалцааны төлөө үндэслэл бүхий хөлс авах, өөрийн гаргасан зардлыг нөхөн төлүүлэх.

14.2. Эрүүгийн, захиргааны, иргэний, зөрчлийн хэрэг, арбитрын маргаан болон Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн бусад эрхийг холбогдох хуулиар тогтооно.

## **15 дугаар зүйл. Өмгөөлөгчийн үүрэг**

15.1. Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараахь үүрэг хүлээнэ:

15.1.1. үйлчлүүлэгчид хэрэг, маргаанд хамаарах хууль, эрх зүйн тогтолцооны талаар болон тэдгээрийн хууль ёсны эрх, үүргийн талаар зөвлөгөө өгөх;

15.1.2. үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах арга, хэрэгсэл ашиглан шударгаар, тууштай хамгаалах;

15.1.3. хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүн болон үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах;

15.1.4. хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн эсэргүүцэл, шаардлагыг үндэслэлтэй тайлбарлах;

15.1.5. хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо холбогдох хуульд заасан журмыг дагаж мөрдөх;

15.1.6. үйлчлүүлэгчийн хүсэл зориг, ашиг сонирхол, шийдвэрийг хүндэтгэх;

15.1.7. үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцааны агуулга, түүний хүрээнд явуулж байгаа үйл ажиллагааны хууль зүйн үр дагавар, хууль тогтоомжийн агуулгыг тайлбарлах;

15.1.8.үйлчлүүлэгчийн зөвшөөрөл шаардлагатай аливаа үйл ажиллагааны талаар түүнд мэдэгдэх;

15.1.9.хууль зүйн мэргэжлийн туслалцааны зорилгод хүрэх арга замын талаар үйлчлүүлэгтэй зөвлөлдөх;

15.1.10.шаардлагатай тохиолдолд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд хууль тогтоомж болон ёс зүйн дүрмээр хориглосон үйлдэл, эс үйлдэхүйн талаар үйлчлүүлэгчид тайлбарлах;

15.1.11.мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах;

15.1.12.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

## **16 дугаар зүйл.Өмгөөлөгчид хориглох зүйл**

16.1.Өмгөөлөгчид өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх явцад дараахь зүйлийг хориглоно:

16.1.1.өөрийн үзэл бодлыг үйлчлүүлэгчид тулгах;

16.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр өмгөөллийн нууцыг задруулах, нийтэд мэдээлэх;

16.1.3.багшлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон өмгөөллийн хуулийн этгээд, Хуульчдын холбоо, түүний хороодод хамаарах, цалин хөлсгүй, эсхүл ашгийн төлөө бус хуулийн этгээдэд хамаарахаас бусад ажил, албан тушаал хавсран эрхлэх;

16.1.4.өмгөөллийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар амлалт өгөх, шашны зан үйл ашиглах, үйлчлүүлэгчийг төөрөгдүүлэх, хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхээс өмнө мөнгө, бэлэг, аливаа шан харамж авах;

16.1.5.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үнэн бодит байдлыг санаатайгаар нуун дарагдуулах;

16.1.6.хуулийг зориуд буруу хэрэглэх, эсхүл худал, эсхүл үндэслэлгүй, эсхүл хэрэг, маргааны материалд авагдаагүй нотлох баримт, баримт сэлтэд үндэслэн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх;

16.1.7.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, хүсэл зоригын эсрэг байр суурь илэрхийлэх, эсхүл аливаа үйлдэл хийх;

16.1.8.хэрэг, маргааныг шийдвэрлэх эрх бүхий этгээд, эсхүл хэрэг, маргааны оролцогчийг ашиглан өөрийн үйлчилгээг бусдад тулгах, үйлчлүүлэгч олж өгсний төлөө бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах;

16.1.9.өөр өмгөөлөгчөөр төлөөлүүлж байгаа өөрийн үйлчлүүлэгчийн эсрэг ашиг сонирхол бүхий хэрэг, маргааны талаас шан харамж авах, тэдгээртэй түүний өмгөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр уулзах;

16.1.10.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатайгаар саад учруулах;

16.1.11.хэрэг, маргааны нөгөө талын нотлох баримт, хэрэгт ач холбогдол бүхий бусад баримт сэлт, мэдээ, мэдээлэл олж авахад нь саад учруулах, тэдгээрт хууль бусаар өөрчлөлт оруулах, устгах, нуун дарагдуулах, бусдыг уг үйл ажиллагаанд хатгах, туслах;

16.1.12.хэрэг, маргааны нөгөө талыг байлцуулахгүйгээр шүүгчтэй уулзах;

16.1.13.хууль, өмгөөлөгч, хуульчийн мэргэжлийн ёс зүйн дүрэмд заасан бусад.

16.2.Өмгөөлөгчийн хувьд хууль болон ёс зүйн хэм хэмжээ нь үйлчлүүлэгчийн хүсэл зориг, шаардлагаас ямагт дээгүүр байна.

16.3.Өмгөөлөгчид хоорондын харилцаа нь хэрэг, маргаанд оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалахад үл нөлөөлнө.

### **17 дугаар зүйл.Өмгөөлөгчийн туслах**

17.1.Өмгөөлөгч нь туслахтай байж болно.

17.2.Өмгөөлөгчийн туслах нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй бөгөөд түүний үйл ажиллагааны үр дүнг өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээд хариуцна.

17.3.Өмгөөлөгчийн туслах нь өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллана.

17.4.Өмгөөлөгчийн туслахын бүртгэлийг Өмгөөлөгчдийн холбоо хөтөлнө. Өмгөөлөгчийн туслахын үйл ажиллагаатай холбоотой харилцааг Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлөөс баталсан журмаар зохицуулна.

17.5.Доор дурдсан хүнийг өмгөөлөгчийн туслахаар ажиллуулахыг хориглоно:

17.5.1.гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлж байсан;

17.5.2.гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлснийг эдэлж дуусаагүй, эсхүл хорих ялыг тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусаагүй;

17.5.3.энэ хуулийн 11.1.2-т заасан үндэслэл байгаа.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **18 дугаар зүйл.Өмгөөлөгчийн бүртгэл, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөл**

18.1.Өмгөөлөгчдийн холбоо өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэлийг хөтөлнө.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасан бүртгэлийг Өмгөөлөгчдийн холбоо, Холбооны салбар зөвлөл, аймаг, нийслэлийн хууль зүйн үйлчилгээ хариуцсан нэгж өөрийн цахим хуудсанд байршуулна.



18.3.Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагааг тогтмол эрхлэх нутаг дэвсгэр /засаг захиргааны нэгж/, ажлын байрны хаяг, утас, цахим шуудангийн хаягийг Өмгөөлөгчдийн холбоонд мэдэгдэнэ.

18.4.Энэ хуулийн 18.3-т заасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол 30 хоногийн дотор Холбооны салбар зөвлөл, Өмгөөлөгчдийн холбоонд бичгээр мэдэгдэж, бүртгэлд өөрчлөлт оруулна.

## **19 дүгээр зүйл.Гадаад улсын өмгөөлөгч Монгол Улсад өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх**

19.1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хуульчийн шалгалтад тэнцэж, энэ хуульд заасны дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүн төрийн болон албаны нууцтай холбоотойгоос бусад асуудлаар өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж болно.

19.2.Гадаадын аль нэг улсад өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий гадаад улсын болон Монгол Улсын харьяат өмгөөлөгч зөвхөн эрх олгосон орны хууль тогтоомж болон олон улсын эрх зүйд хамаарах асуудлаар өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлнэ.

19.3.Энэ хуулийн 19.2-т заасан өмгөөлөгч хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу Өмгөөлөгчдийн холбоонд бүртгүүлснээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхлэх эрхтэй болох бөгөөд хуульд тусгайлан зохицуулснаас бусад тохиолдолд энэ хуульд заасан ерөнхий нөхцөл, шаардлагын дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлнэ.

19.4.Өмгөөлөгч гадаад улсын иргэний харьяалалтай болсон нь энэ хуулийн 19.1-д зааснаас бусад байдлаар түүний өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

## **20 дугаар зүйл.Өмгөөллийн үйл ажиллагааны хэлбэр**

20.1.Өмгөөллийн үйл ажиллагаа дараахь хэлбэртэй байна:

20.1.1.хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр лавлагаа, зөвлөгөө өгөх, зөвлөмж, дүгнэлт гаргах;

20.1.2.хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх зохиох;

20.1.3.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох;

20.1.4.захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох;

20.1.5.иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох;

20.1.6.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох;

20.1.7.зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох;

20.1.8.олон улсын шүүх, арбитрын ажиллагаа болон хэрэг, маргаан шийдвэрлэх бусад байгууллагад үйлчлүүлэгчийг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох;

20.1.9.шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох;

20.1.10.эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эрхлэх, уг үйл ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох;

20.1.11.төрийн болон бусад байгууллагад үйлчлүүлэгчийг төлөөлөх, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах.

## **21 дүгээр зүйл.Өмгөөллийн үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр**

21.1.Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагааг ганцаарчлан, гэрээгээр хамтарч, эсхүл хуулийн этгээд байгуулан эрхэлж болно.

21.2.Өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаагаа ямар хэлбэрээр эрхэлж байгаагаас үл хамааран ажлын байр, банкинд харилцах данстай байна.

21.3.Энэ хуулийн 21.2-т заасан нь өмгөөллийн хуулийн этгээдийн гишүүн өмгөөлөгч болон тэдгээрт ажиллаж байгаа өмгөөлөгчид хамаарахгүй.

## **22 дугаар зүйл.Өмгөөллийн хуулийн этгээд**

22.1.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд /цаашид “Өмгөөллийн хуулийн этгээд” гэх/-ийн хэлбэр нь хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл байна.

22.2.Өмгөөллийн хуулийн этгээдийн оноосон нэрийн урд “өмгөөллийн” гэсэн үгийг хэрэглэнэ.

22.3.Өмгөөллийн хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 14 хоногийн дотор хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг, түүнд ажиллах өмгөөлөгчдийн нэрсийг Өмгөөлөгчдийн холбоонд бүртгүүлэх бөгөөд уг бүртгэлд өөрчлөлт орсон тухай бүрт Өмгөөлөгчдийн холбоонд бичгээр мэдэгдэнэ.

22.4.Өмгөөллийн хуулийн этгээд нь өмгөөллийн үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

22.5.Өмгөөллийн хуулийн этгээдийн гишүүн, удирдах, төлөөлөх эрх бүхий этгээд нь өмгөөлөгч байна.

22.6.Өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээд нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээдтэй хамтарч ашиг хуваах байдлаар үйл ажиллагаа эрхэлж болохгүй.

22.7.Өмгөөллийн хуулийн этгээдийн энэ хуульд заагаагүй бусад харилцааг Нөхөрлөлийн тухай хуулиар зохицуулна.

## **23 дугаар зүйл.Ашиг сонирхлын зөрчилтэй хэрэг, маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцохыг хориглох**

23.1.Өмгөөлөгч дараахь тохиолдолд үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг хориглоно:

23.1.1.хэрэг, маргааны үр дүнгийн талаар үйлчлүүлэгчээс өөр ашиг сонирхолтой;

23.1.2.хэрэг, маргааныг хянан шалгах, шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөс бусад оролцогчийн хувиар оролцож байсан, эсхүл үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг хөндсөн маргаан бүхий шийдвэрийг гаргах эрх бүхий ажил, албан тушаал эрхэлж байсан;

23.1.3.хэрэг, маргааныг хянан шалгах, шийдвэрлэх ажиллагаанд оролцсон, эсхүл оролцож байгаа этгээдтэй төрөл садангийн, эсхүл гэр бүлийн харилцаатай;

23.1.4.хэрэг, маргааны үр дүнгийн талаар үйлчлүүлэгчийн эсрэг ашиг сонирхол бүхий өөр этгээдэд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлж байгаа;

23.1.5.хэрэг, маргааныг хянан шалгаж, эсхүл шийдвэрлэж байгаа байгууллагад, эсхүл түүний үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий ажил, албан тушаал эрхэлж байсан бөгөөд түүнээс хойш 3 жилийн хугацаа өнгөрөөгүй;

23.1.6.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.1-д засан нөхцөл байдал үүссэн;

23.1.7.оролцож байгаа хэрэг, маргааны нөгөө тал буюу хэрэг, маргааны үр дүнгийн талаар эсрэг ашиг сонирхолтой этгээд, эсхүл түүний төлөөлөгч, өмгөөлөгчтэй өөр хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд нэг тал болж оролцож байгаа;

23.1.8.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчтой хамаарал бүхий этгээдийн харилцаатай;

23.1.9.тухайн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцож байсан, эсхүл гэрчээр оролцох хангалттай үндэслэлтэй;

23.1.10.урьд өмнө хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлсэн этгээд болон гуравдагч этгээдийн өмнө хууль, аливаа хэлцэлээр хүлээсэн үүрэг нь тухайн үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцааг шударгаар үзүүлэхэд харшлах бусад тохиолдол.

23.2.Өмгөөллийн нэг хуулийн этгээдэд харьяалагдах, эсхүл ашгаа хуваах байдлаар хамтран ажилладаг өмгөөлөгчид харилцан эсрэг ашиг сонирхол бүхий хэрэг, маргааны талуудад нэгэн зэрэг хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг хориглоно.

23.3.Өмгөөлөгч энэ хуулийн 23.1-д заасан нөхцөл байдлын талаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлж эхлэхээс өмнө мэдсэн бол хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхээс татгалзах, түүнийг үзүүлэх явцад олж мэдсэн тохиолдолд хууль зүйн мэргэжлийн туслалцааг дуусгавар болгох үүрэгтэй.

## **24 дүгээр зүйл.Хууль зүйн мэргэжлийн туслалцааг дуусгавар болгох**

24.1.Өмгөөлөгч хуульд заасан үндэслэлээр үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцааг үргэлжлүүлэн үзүүлэх боломжгүй болсон бол хууль зүйн мэргэжлийн туслалцааг гэрээнд заасан хугацаанаас өмнө дуусгавар болгоно.

24.2.Энэ хуулийн 24.1-д заасан тохиолдол үүссэн, эсхүл үүсэх нь тодорхой болсон тохиолдолд өмгөөлөгч үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй бөгөөд хууль зүйн мэргэжлийн туслалцаа үргэлжлүүлэн үзүүлэх өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээдийг үйлчлүүлэгчид санал болгож болно.

24.3.Энэ хуулийн 24.1-д заасан тохиолдолд өмгөөлөгч хууль зүйн мэргэжлийн туслалцааг дуусгавар болгох үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл болон үйлчлүүлэгчид үзүүлсэн хууль зүйн мэргэжлийн туслалцаатай холбоотой баримт бичиг, эд зүйл, үйлчлүүлэгчид буцаан төлбөл зохих өмгөөллийн хөлсийг хүлээлгэн өгөх зэрэг шаардлагатай арга хэмжээ авна.

## **25 дугаар зүйл.Өмгөөлөгчийн хүсэлт**

25.1.Хуульд өөрөөр заагаагүй бол өмгөөлөгч хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай лавлагаа, тодорхойлолт, баримт бичгийг тухайн асуудлыг хариуцсан төрийн болон төрийн бус байгууллагаас гаргуулан авах зорилгоор өмгөөлөгчийн хүсэлт гаргана.

25.2.Өмгөөлөгчийн хүсэлтийг хүлээн авсан төрийн болон төрийн бус байгууллага 14 хоногийн дотор бичгээр хариу өгөх үүрэгтэй. Хүсэлтэд заасан баримт бичиг, мэдээллийг цуглуулахад нэмэлт хугацаа шаардлагатай тохиолдолд нэг удаа 14 хоногоор сунгаж болно.

25.3.Өмгөөлөгчийн хүсэлтийн загварыг Өмгөөлөгчдийн холбоо батална.

25.4.Төрийн болон төрийн бус байгууллага доор дурдсан тохиолдолд өмгөөлөгчийн хүсэлтэд заасан мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөхөөс татгалзана:

25.4.1.өмгөөлөгчийн хүсэлтэд заасан мэдээлэл, баримт бичиг нь тухайн байгууллагын эрхлэх асуудал, чиг үүрэгт хамаарахгүй, эсхүл тухайн байгууллагад байхгүй;

25.4.2.өмгөөлөгчийн хүсэлт нь энэ хуулийн 25.3-т заасан шаардлагыг хангаагүй;

25.4.3.өмгөөлөгчийн хүсэлтэд заасан баримт бичиг, мэдээ, мэдээлэл нь хууль тогтоомжийн дагуу төрийн болон албаны нууц, эсхүл байгууллага, хувь хүний нууцад хамаарах бол.

25.5.Хуульд өөрөөр заагаагүй бол Өмгөөлөгчийн хүсэлтийг энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх үүргээ биелүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

25.6.Өмгөөлөгчийн хүсэлтэд заасан баримт бичиг, мэдээ, мэдээллийг бусдад дамжуулах, ашиглах талаар хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актаар энэ хуульд зааснаас өөр журам тогтоосон бол тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

## **26 дугаар зүйл.Хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг хангах**

26.1.Өмгөөлөгч үйлчлүүлэгчийг итгэмжлэл, хүсэлт, эсхүл Өмгөөлөгчдийн холбооноос олгосон томилолтын үндсэн дээр төлөөлөх бөгөөд хэн боловч өмгөөлөгч болон түүний үйлчлүүлэгчээс хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээ, түүний хуулбарыг шаардах эрхгүй.

26.2.Хууль зүйн мэргэжлийн туслалцаа хүсэгч нь өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээдэд хандаж хэлцэл хийх, эсхүл Өмгөөлөгчдийн холбоонд хүсэлт гаргах замаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхээ хангуулна.

26.3.Иргэн, хуулийн этгээд хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхээ хэрэгжүүлэх асуудлаар хандсан бол Өмгөөлөгчдийн холбоо, мөрдөгч, прокурор, шүүгч нь өмгөөлөгч болон өмгөөллийн хуулийн этгээдийн нэр, хаягийн лавлагаа өгөх үүрэгтэй.

26.4.Хууль зүйн мэргэжлийн туслалцаа хүсэгчид тодорхой өмгөөлөгчийн нэр заах, үйлчилгээг нь авхуулахаар тулгахыг хориглоно.

26.5.Иргэн, хуулийн этгээдийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг хангах зорилгоор эрх бүхий албан тушаалтан, мөрдөгч, прокурор, шүүгч нь өмгөөлөгч болон өмгөөллийн хуулийн этгээдийн нэр, хаягийн лавлагааг өгөх үүрэгтэй.

## **27 дугаар зүйл.Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээ**

27.1.Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ үйлчлүүлэгчид, эсхүл түүний сонгосон этгээдтэй хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх тухай гэрээг бичгээр байгуулна.

27.2.Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээнд дараахь зүйлийг тусгасан байна:

27.2.1.өмгөөлөгчийн нэр, хаяг;

27.2.2.өмгөөлийн хуулийн этгээдийн нэр, хаяг;

27.2.3.өмгөөллийн үйл ажиллагааны хэлбэр, түүний агуулга;

27.2.4.хууль зүйн мэргэжлийн туслалцааны төлбөрийн хэмжээ, түүнийг төлөх нөхцөл, дансны дугаар;

27.2.5.хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх явцад өмгөөлөгчөөс гарах зардлыг нөхөн төлөх нөхцөл;

27.2.6.өмгөөлөгчийн хариуцлагын хэлбэр болон хэмжээ;

27.2.7.гэрээг цуцлах нөхцөл.

27.3.Энэ хуулийн 27.2-т зааснаас бусад нөхцөлийг талууд харилцан тохиролцож тогтоож болно.

## **28 дугаар зүйл.Өмгөөллийн хөлс**

28.1.Өмгөөлөгч хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхдээ үйлчлүүлэгчээс хөлс /цаашид “өмгөөллийн хөлс” гэх/ авах бөгөөд хэмжээг өмгөөлөгч, үйлчлүүлэгч гэрээгээр харилцан тохиролцож тогтооно.

28.2.Өмгөөллийн хөлсийг тогтооход дараахь нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

28.2.1.хэрэг, маргаан, үйлчлүүлэгчийн хүсэлт, даалгаврын цар хүрээ, ээдрээ төвөгтэй байдал;

28.2.2.үйлчлүүлэгчийн хүсэлт, даалгаврыг биелүүлэхэд зарцуулах хугацаа буюу тухайн хэрэг, маргааны үргэлжлэх хугацаа;

28.2.3.өмгөөлөгчийн мэргэшсэн байдал, туршлага, мэргэжлийн ур чадвар;

28.2.4.үйлчлүүлэгчийн хүсэлт, даалгаврыг биелүүлсэн байх хугацаа;

28.2.5.тусгай мэдлэг шаардах асуудлаар мэргэжлийн байгууллага, иргэнийг туслалцаа авах шаардлагатай эсэх;

28.2.6.өмгөөллийн хөлсийг тогтооход шаардлагатай бусад.

28.3.Өмгөөлөгч болон үйлчлүүлэгч харилцан тохиролцсон тохиолдолд хөрөнгийн талаархи хэрэг, маргаанд үзүүлсэн хууль зүйн мэргэжлийн туслалцааны үр дүнгээс хамаарсан доор дурдсанаас бусад тохиолдолд өмгөөллийн хөлсийг нөхцөлтэйгээр тохиролцож болно:

28.3.1.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа;

28.3.2. эцэг тогтоолгох, тэтгэмж тогтоолгох, гэрлэлт цуцлах болон гэр бүлийн дундын өмчийн маргааныг шийдвэрлэх.

28.4.Өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ эд хөрөнгийн болон бусад байдлыг нь харгалзан түүнийг өмгөөллийн хөлс төлөхөөс чөлөөлж болно.

28.5.Өмгөөллийн хөлс болон өмгөөлөгчөөс гарсан зардлын нөхөн төлбөрийг энэ хуулийн 21.2-т заасан дансаар шилжүүлэн авна.

## **29 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн мэргэжлийн хариуцлагын даатгал**

29.1.Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээний нөхцөл, шаардлагыг зөрчсөн, эсхүл мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутсаны улмаас өмгөөллийн үйл ажиллагаанд алдаа гаргаж, үйлчлүүлэгчид хохирол учруулсан тохиолдолд түүнийг нөхөн төлөх зорилгоор өмгөөлөгч мэргэжлийн хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

29.2.Өмгөөлөгчийн мэргэжлийн хариуцлагын даатгалын үнэлгээний хэмжээ буюу даатгалын тохиолдолд олгох нөхөн төлбөрийн доод хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо тогтоох бөгөөд өмгөөлөгчийг хариуцлагын даатгалд даатгуулах ажлыг Өмгөөлөгчдийн холбоо зохион байгуулна.

## **30 дугаар зүйл.Өмгөөллийн нууц**

30.1.Өмгөөлөгчөөс өөрийн үйлчлүүлэгчид үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцаатай холбоотой бүхий л мэдээлэл өмгөөллийн нууцад хамаарна.

30.2.Үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх болон бусад этгээдээс хууль зүйн мэргэжлийн туслалцаа хүсч өмгөөлөгчид хандах явцад олж мэдсэн зүйлтэй нь холбогдуулан өмгөөлөгчийг гэрчээр байцаах, тайлбар авахыг хориглоно.

30.3.Өмгөөлөгч өмгөөллийн нууцыг үйлчлүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад задлах, үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд харшлах байдлаар, эсхүл хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын тулд ашиглахыг хориглоно.

30.4.Өмгөөллийн нууцыг хугацаагүй хадгална.

30.5.Энэ хуулийн 30.2, 30.3-т заасан нь хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэх явцад өмгөөллийн нууцыг олж мэдсэн өмгөөлөгчийн туслах, өмгөөллийн хуулийн этгээдийн бусад ажилтанд нэгэн адил хамаарна.

30.6.Өмгөөлөгч болон үйлчлүүлэгчийн хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх, бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй бодит аюулыг зайлуулах, эсхүл өмгөөлөгчид холбогдуулан үүсгэсэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өмгөөлөгч өөрийн тайлбар, мэдүүлэг, бусад нөхцөл байдлыг нотолбол зохих хэмжээнд өмгөөллийн нууцыг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр задруулж болно.

30.7.Энэ зүйлд заасан үйлчлүүлэгчийн нууцыг хамгаалах тухай зохицуулалт нь Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад мэдээлэх үүрийг хэрэгжүүлэхэд хамаарахгүй.

*Тайлбар: -Энэ зүйлд заасан “үйлчлүүлэгч” гэдэгт энэ хуулийн 4.1.4-т зааснаас гадна өмгөөллийн үйлчилгээ авахаар өмгөөлөгчид хандсан иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.*

### **31 дүгээр зүйл.Өмгөөллийн үйл ажиллагааны баталгаа**

31.1.Хуульд заасны дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, дуусгавар болгосноос бусад тохиолдолд төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэх болон үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг төлөөлөх эрхийг хязгаарлахыг хориглоно.

31.2.Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, улс төрийн нам, хуулийн этгээд, иргэн хэн боловч өмгөөлөгч хуулийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэхэд нь дарамт шахалт үзүүлэх, саад учруулах, баталгаа шаардах, заналхийлэх буюу бусад байдлаар хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

31.3.Хуульд өөрөөр заагаагүй бол өмгөөллийн үйл ажиллагаатай нь холбогдуулан өмгөөлөгч, өмгөөлөгчийн туслах, өмгөөллийн хуулийн этгээдийн ажилтны яриаг чагнах, албан байр болон орон байр, тээврийн хэрэгсэл, биед нь

үзлэг, нэгжлэг хийх, мөрдөн мөшгих, өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг гаргуулан авахыг хориглоно.

### **32 дугаар зүйл.Өмгөөллийн үйл ажиллагааны талаархи зар сурталчилгаа**

32.1.Өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээд өөрийн үзүүлж байгаа өмгөөллийн үйл ажиллагааны талаар зар, сурталчилгаа явуулах эрхтэй.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасан зар сурталчилгаа нь өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээдийн талаар ерөнхий мэдээлэл, ажлын туршлага, боловсролын байдал болон үзүүлэх хууль зүйн мэргэжлийн туслалцааны талаархи мэдээллийг агуулгасан байх бөгөөд доор дурдсан агуулгатай байхыг хориглоно:

32.2.1.өмгөөллийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар тодорхой амлалт өгсөн;

32.2.2.тухайн өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээдийн үйлчилгээг авахыг тулган шаардсан;

32.2.3.бусад өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээдийн нэр хүндэд халдсан;

32.2.4.өөрийн болон бусад өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээдийн үйл ажиллагааны талаар үнэлгээ, дүгнэлт өгсөн;

32.2.5.өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой хуурамч, эсхүл төөрөгдүүлсэн мэдээлэл агуулсан;

32.2.6.энэ хууль болон ёс зүйн дүрэмд нийцээгүй бусад.

32.3.Өмгөөллийн үйл ажиллагааны талаархи зар, сурталчилгаанд тавих шаардлагыг Удирдах зөвлөл батална.

## **ТАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЧИГ ҮҮРЭГ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **33 дугаар зүйл.Монголын Өмгөөлөгчдийн холбоо**

33.1.Монголын Өмгөөлөгчдийн холбоо /цаашид “Холбоо” гэх/ нь өмгөөлөгчдийн заавал гишүүнчлэлтэй, мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага мөн.

33.2.Холбоо нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.

### **34 дүгээр зүйл.Холбооны чиг үүрэг**

34.1.Холбоо нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

34.1.1.өмгөөллийн үйл ажиллагааны нэгдсэн шаардлага, өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг тогтоох;



34.1.2.иргэдийн хуульд заасан эрх, үүрэг болон тэдгээрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаархи өмгөөлөгчийн үүрэг, оролцоог сурталчилан таниулах;

34.1.3.нийгмийн бүхий л давхарга, бүлэг хууль зүйн мэргэжлийн туслалцааг тэгш, хүртээмжтэй үзүүлэх, өмгөөлөгчдөөс өмгөөллийн үйл ажиллагааг хараат бусаар эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх талаар төрийн бүх шатны байгууллагатай хамтран ажиллах;

34.1.4.өмгөөлөгчдийн мэргэжлийн ёс зүй, мэдлэг, ур чадвар, өмгөөлөгчөөс үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцааны чанарыг дээшлүүлэх;

34.1.5.гишүүдээс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөл боломжийг сайжруулах;

34.1.6.хуульд заасан үндэслэл, журмын дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, дуусгавар болгох;

34.1.7.өмгөөлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийт өмгөөлөгчдийн ашиг сонирхлыг төрийн аль ч шатны байгууллагад төлөөлөх;

34.1.8.шаардлагатай тохиолдолд өмгөөлөгчдөөс хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ажлыг зохион байгуулах;

34.1.9.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

34.2.Төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтны шийдвэр нь өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл Холбоо өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн холбогдох байгууллага, албан тушаалтан, шүүхэд санал, гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй.

34.3.Холбооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой энэ хуульд заагаагүй бусад харилцааг Холбооны дүрмээр зохицуулна.

### **35 дугаар зүйл.Холбооны бэлгэ тэмдэг**

35.1.Холбоо өөрийн бэлгэ тэмдэгтэй байна.

35.2.Холбооны бэлгэ тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журмыг Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөл батална.

### **36 дугаар зүйл.Холбооны Их Хурал**

36.1.Холбооны эрх барих дээд байгууллага нь Өмгөөлөгчдийн холбооны Их Хурал /цаашид “Их Хурал” гэх/ байна.

36.2.Их Хурал ээлжит болон ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг гурван жилд нэг хуралдуулна.

36.3.Их Хурал Холбооны гишүүдийн төлөөллөөс бүрдэнэ.

36.4.Их Хурлын төлөөлөгчдийн тоог салбар зөвлөлд харьяалагдах өмгөөлөгчдийн тооноос хамааран тогтоох бөгөөд төлөөлөгчийг сонгох, Их Хурлыг хуралдуулахтай холбогдсон журмыг Холбооны дүрмээр тогтооно.

36.5.Их Хуралд төлөөлөгчөөр сонгогдсон эсэхээс үл хамааран Холбооны гишүүн өөрийн хүсэлтээр Их Хуралд саналын эрхгүйгээр оролцож болно.

36.6.Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

36.6.1.Холбооны дүрмийг батлах;

36.6.2.өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх нэгдсэн шаардлагыг тогтоож, мөрдүүлэх;

36.6.3.Холбооны бодлого, хөгжлийн хөтөлбөрийг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

36.6.4.Холбооны санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, уг төлөвлөгөөг хэрэгжүүлсэн тайланг хэлэлцэн батлах;

36.6.5.өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, ёс зүйн маргааныг хянан шийдвэрлэх журмыг батлах;

36.6.6.Өмгөөлөгчдийн холбооны Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах;

36.6.7.Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөл, Өмгөөлөгчдийн холбооны Хяналтын зөвлөл болон Мэргэжлийн хариуцлагын хороо, Мэргэшлийн хорооны гишүүнийг сонгох, чөлөөлөх;

36.6.8.Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх, түүний цалингийн хэмжээг тогтоох;

36.6.9.Холбооны гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг тогтоох;

36.6.10.Холбооны салбар зөвлөлийг байгуулах, татан буулгах, салбар зөвлөлийн үйл ажиллагааны журмыг батлах;

36.6.11.Холбооны шагналыг бий болгох, түүнийг олгох журмыг батлах;

36.6.12.хууль, дүрэмд заасан бусад бүрэн эрх.

36.7.Их Хурлын ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулахтай холбогдсон харилцааг Холбооны дүрмээр зохицуулна.

36.8.Их Хурлын тов болон хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хурал эхлэхээс 30 хоногийн өмнө Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөл өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

36.9.Их Хурал сонгогдсон төлөөлөгчдийн олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болно.

36.10.Их Хурал асуудлыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн саналаар шийдвэрлэж, шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана.

### **37 дугаар зүйл.Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөл**

37.1.Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/нь Их Хурлын чөлөөт цагт Холбооны үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий хамтын удирдлагын байгууллага байна.

37.2.Удирдах зөвлөл 21 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд энэ хуулийн 37.4.4-т зааснаас бусад тохиолдолд бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байна. Энэ хуулийн 37.4.4-т заасны дагуу нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай тэнцүү байна.

37.3.Өмгөөлөгч нь Удирдах зөвлөлийн гишүүнээр хоёроос дээш удаа сонгогдохгүй.

37.4.Удирдах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

37.4.1.Холбооны жилийн ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

37.4.2.өмгөөллийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, Холбооны бодлого, хөгжлийн хөтөлбөр, Холбооны дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих;

37.4.3.Их Хурлыг зохих журмын дагуу зарлан хуралдуулах;

37.4.4.Их Хурлын чөлөөт цагаар Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Мэргэжлийн хариуцлагын хороо, Мэргэшлийн хорооны гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд түүний бүрэн эрхийг хугацааны өмнө дуусгавар болгох тухай шийдвэр гаргах, нөхөн сонгох;

37.4.5.Холбооны жилийн төсвийг баталж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх;

37.4.6.Холбооны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар өмгөөлөгчдөөс гаргасан санал, гомдлыг хэлэлцэж шийдвэрлэх;

37.4.7.Холбооны Ажлын албаны бүтэц, орон тоо, ажилтны цалингийн хэмжээг тогтоох;

37.4.8.Холбооны салбар зөвлөлийн даргыг томилох, чөлөөлөх;

37.4.9.хууль тогтоомж, Холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

37.5.Удирдах зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд нийт гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

37.6.Яаралтай шийдвэр гаргах шаардлагатай цаг үеийн асуудлаар Холбооны Ерөнхийлөгч Удирдах зөвлөлийг тухай бүр зарлан хуралдуулна.

37.7.Удирдах зөвлөл асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

37.8.Удирдах зөвлөлийн шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

37.9.Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч Удирдах зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн санал тэнцсэнээс бусад тохиолдолд саналын эрхгүй байна.

*Тайлбар: -Энэ хуулийн 37.4.4-т заасан “хүндэтгэн үзэх шалтгаан” гэж энэ хуулийн 9.1, 10.1, 11.1-т заасан үндэслэл болон шүүгч, прокурор, Хуульчдын холбоо, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнийг ойлгоно.*

### **38 дугаар зүйл.Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч**

38.1.Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч /цаашид “Ерөнхийлөгч” гэх/ нь Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

38.2.Ерөнхийлөгчөөр 30 нас хүрсэн, өмгөөллийн үйл ажиллагааг 5-аас доошгүй жил эрхэлсэн, Холбооны гишүүн Монгол Улсын иргэнийг Их Хурал нууц санал хураалтаар сонгоно.

38.3.Ерөнхийлөгчийг 3 жилийн хугацаагаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.

38.4.Ерөнхийлөгч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

38.4.1.Удирдах зөвлөлийн хуралдааныг зарлан хуралдуулах, даргалах;

38.4.2.Холбоог гадаад, дотоод харилцаанд төлөөлөх;

38.4.3.Холбооны нэрийн өмнөөс гэрээ, хэлэлцээр байгуулах, хууль тогтоомж, Холбооны дүрэмд заасан хязгаарт багтаан Холбооны хөрөнгийг захиран зарцуулах;

38.4.4.Ажлын албаны ажилтныг томилох, чөлөөлөх;

38.4.5.Холбооны салбар, зөвлөлийн даргыг томилох, чөлөөлөх саналыг Удирдах зөвлөлд оруулах;

38.4.6.Их Хурал, Удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулах;

38.4.7.энэ хууль болон дүрмээр олгосон бусад бүрэн эрх.

### **39 дүгээр зүйл.Холбооны Ажлын алба**

39.1.Холбоо нь өөрийн чиг үүрэг, өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын албатай байна.

39.2.Ажлын албыг Ерөнхийлөгч тэргүүлнэ.

39.3.Ажлын албаны ажилтан өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээд байх бөгөөд хэрэв өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй бол уг эрхийг түдгэлзүүлнэ.

39.4.Ажлын алба нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

39.4.1.Их Хурал, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгчийн шийдвэр, үүрэг, даалгаврыг биелүүлэх;

39.4.2.Холбооны зөвлөл, хороодын өдөр тутмын үйл ажиллагаа, тэдгээрийн ажлын уялдаа холбоог зохион байгуулах;

39.4.3.өмгөөлөгчдийг мэдээллээр хангах, тэдгээрийн хооронд мэдээлэл, туршлага солилцох нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

39.4.4.Их Хурал, Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох шийдвэрийн төслийг бэлтгэх;

39.4.5.өмгөөлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг зохион байгуулах;

39.4.6.Өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэл, өмгөөллийн хуулийн этгээдийн бүртгэлийг хариуцан хөтлөх, цахим сан бүрдүүлэх;

39.4.7.иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээдийн талаархи мэдээллээр хангах;

39.4.8.Холбооны дүрэмд заасан бусад.

#### **40 дүгээр зүйл.Өмгөөлөгчдийн Холбооны Хяналтын зөвлөл**

40.1.Өмгөөлөгчдийн холбооны Хяналтын зөвлөл /цаашид “Хяналтын зөвлөл” гэх/ нь Холбооны эд хөрөнгийн хуримтлал, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаа болон Холбооны үйл ажиллагааны талаархи санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

40.2.Хяналтын зөвлөл нь үйл ажиллагаагаа Их Хурлын өмнө хариуцан тайлагнана.

40.3.Хяналтын зөвлөл нь долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь гурван жил байна.

40.4.Холбооны санхүүгийн асуудал хариуцсан ажилтан, Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхийлөгч нь Хяналтын зөвлөлийн гишүүн, дарга байхыг хориглоно.

#### **41 дүгээр зүйл.Өмгөөлөгчдийн холбооны Мэргэшлийн хороо**

41.1.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Мэргэшлийн хороо /цаашид “Мэргэшлийн хороо” гэх/ Холбооны дэргэд ажиллана.

41.2.Мэргэшлийн хороо нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд хорооны бүрэлдэхүүнд шүүх, прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хуульчдын холбооноос тус бүр нэг, Өмгөөлөгчдийн Холбооноос таван төлөөлөл байна.

41.3.Энэ хуулийн 41.2-т заасан Өмгөөлөгчдийн Холбооны төлөөллийн хоёр нь хуульч эрдэмтэн байна.

41.4.Мэргэшлийн хорооны даргыг уг хорооны гишүүдийн дотроос тэдгээрийн олонхийн саналаар сонгох бөгөөд дарга болон гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.

41.5.Мэргэшлийн хорооны гишүүдийн дийлэнх олонхи хуралд оролцсноор хурлыг хүчин төгөлдөрт тооцох ба асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ.

41.6.Мэргэшлийн хорооны шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

41.7.Мэргэжлийн хорооны ажиллах журмыг Их Хурал батална.

#### **42 дугаар зүйл.Холбооны Ерөнхийлөгч, зөвлөл, хорооны гишүүний өмгөөлөх эрх, урамшуулал**

42.1.Холбооны Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Мэргэшлийн хороо, Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх болон Их Хурал, Удирдах зөвлөлөөс тогтоосон хэмжээгээр цалин хөлс, урамшуулал, нөхөн төлбөр авах эрхтэй.

#### **43 дугаар зүйл.Холбооны хөрөнгө, аудит**

43.1.Холбооны хөрөнгө нь гишүүнчлэлийн хураамж, хандив, тусламж, сургалтын хураамж, хэвлэн нийтлэлийн ашгаас бүрдэнэ.

43.2.Холбооны санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн бүрдүүлэлт, зарцуулалт нь Холбооны гишүүд болон олон нийтэд ил тод байна.

43.3.Холбооны санхүүгийн үйл ажиллагаанд 2 жил тутамд нэг удаа санхүүгийн аудит хийлгэж, үр дүнг Холбооны гишүүд болон олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ**

#### **44 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн хариуцлага**

44.1.Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаандаа баримтлах Мэргэжлийн ёс зүйн дүрэм /цаашид “Ёс зүйн дүрэм” гэх/-тэй байна.

44.2.Ёс зүйн дүрэм нь өмгөөлөгчид хариуцлага хүлээлгэх үндэслэл, журам болон өмгөөллийн үйл ажиллагаанд заавал дагаж мөрдвөл зохих ёс зүйн хэм хэмжээг агуулсан байна.

44.3.Энэ хууль болон Хуульчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг зөрчсөн өмгөөлөгчид доор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

44.3.1.хаалттай, эсхүл нээлттэй сануулах;

44.3.3.өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нэгээс гурван жил хүртэл хугацаагаар зогсоох;

44.3.4.өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгох;

44.4.Зөрчил гаргасан өмгөөлөгчид өөрт нь ганцаарчлан сануулахыг “хаалттай сануулах”, нийтэд зарлаж сануулахыг “нээлттэй сануулах” гэнэ.

44.5.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хугацаатай зогсоосон бол уул хугацаа өнгөрснөөр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхээ сэргээх хүсэлт гаргах эрхтэй.

44.6.Энэ хуулийн 44.5-д заасны дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг сэргээх эсэхийг Өмгөөлөгчийн мэргэжлийн хариуцлагын хорооны дүгнэлтийг үндэслэн Мэргэшлийн хороо шийдвэрлэнэ. Өмгөөлөгчийн мэргэжлийн хариуцлагын хороо өмгөөллийн үйл ажиллагаа эрхийг нь зогсоосон хуульчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг сэргээх боломжгүй гэж үзсэн бол зургаан сарын дараа дахин хүсэлт гаргаж болно.

44.7.Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгосон бол дахин эрх авахаар хүсэлт гаргах эрхгүй.

44.8.Энэ хуулийн 44.3-т заасан хариуцлага хүлээлгэхэд өмгөөлөгчийн гаргасан зөрчил, түүний шинж чанар, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, гэм буруугийн хэлбэр болон Мэргэжлийн хариуцлагын хороо ач холбогдолтой гэж үзсэн бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

44.9.Өмгөөлөгч ёс зүйн зөрчил гаргаснаас хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн бол хариуцлага хүлээлгэхгүй. Маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно.

44.10.Өмгөөлөгчид энэ хуулийн дагуу хариуцлага хүлээлгэсэн нь түүнийг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

#### **45 дугаар зүйл.Мэргэжлийн хариуцлагын хороо, түүний чиг үүрэг**

45.1.Өмгөөлөгчийн мэргэжлийн хариуцлагын хороо /цаашид “Мэргэжлийн хариуцлагын хороо” гэх/ нь өмгөөлөгч энэ хууль болон өмгөөлөгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх, өмгөөллийн үйл ажиллагааны нэгдсэн шаардлагыг боловсруулах, энэ хууль болон өмгөөлөгчийн ёс зүйн дүрмийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

45.2.Мэргэжлийн хариуцлагын хороо нь 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.

45.3.Мэргэжлийн хариуцлагын хорооны дарга, гишүүнийг хоёроос дээш удаа улируулан сонгохгүй.

45.4.Мэргэжлийн хариуцлагын хорооны бүрэлдэхүүнд шүүгч, прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хуульчдын холбоо, иргэдийн төлөөлөл тус бүр нэг, Холбооны төлөөлөл зургаа байна.

45.5.Мэргэжлийн хариуцлагын хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын албатай байх бөгөөд ажлын албаны бүтэц, орон тоог Мэргэжлийн хариуцлагын хорооны даргын саналыг үндэслэн Удирдах зөвлөл батална.

45.6.Энэ хуулийн 45.1-д заасан иргэдийн төлөөлөл нь өмгөөллийн үйл ажиллагааны талаар хувийн ашиг сонирхолгүй, хуульч бус, урьд өмнө өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж байгаагүй Монгол Улсын иргэн байх бөгөөд түүнд тавигдах шаардлага, сонгох журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

45.7.Энэ хуулийн 45.1-д заасан шүүх, прокурорын төлөөлөл нь шүүгч, прокуророор 7-оос доошгүй жил ажилласан байна. Шүүгчийг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн, прокурорыг Улсын Ерөнхий прокурорын, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор томилно.

45.8.Энэ хуулийн 45.1-д заасан Хуульчдын холбооны төлөөлөл нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй хуульч байх бөгөөд Хуульчдын холбооны Зөвлөлөөс санал болгосноор томилно.

#### **46 дугаар зүйл.Мэргэжлийн хариуцлагын хорооны бие даасан байдал, чиг үүргээ хэрэгжүүлэх баталгаа**

46.1.Мэргэжлийн хариуцлагын хороо нь шаардлагатай тохиолдолд хүсэлт, гомдол, мэдээлэлд дурдсан үйлдэл, эс үйлдэхүйн талаар холбогдох этгээдээс лавлагаа, тодорхойлолт авах, Мэргэжлийн хариуцлагын хороонд ирж тайлбар өгөхийг шаардах эрхтэй бөгөөд холбогдох иргэн, хуулийн этгээд нь үнэн зөв тайлбар өгөх болон Мэргэжлийн хариуцлагын хорооны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

46.2.Мэргэжлийн хариуцлагын хорооны дарга Ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг томилж, эсхүл чөлөөлнө.

46.3.Мэргэжлийн хариуцлагын хороо нь бие даасан, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай төсөвтэй байна.

46.4.Мэргэжлийн хариуцлагын хорооны төсвийг Ажлын албаны дарга бие даан захиран зарцуулж, хариуцлага хүлээх бөгөөд төсвийг үндэслэлгүйгээр өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.

46.5.Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн, Ажлын албаны гүйцэтгэх болон удирдах албан тушаалтан нь маргаан хянан шийдвэрлэх чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх бөгөөд Холбооны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдээс тэдгээрийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөхийг хориглоно.

46.6.Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүн, Ажлын албаны гүйцэтгэх болон удирдах албан тушаалтны ёс зүйд тавигдах шаардлагыг Ёс зүйн дүрэмд тусгайлан заана.

#### **47 дугаар зүйл.Маргаан үүсгэх**

47.1.Мэргэжлийн хариуцлагын хороо энэ хуулийн 45.1-д заасан маргааныг өөрийн санаачлагаар, Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны дүгнэлт, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгчийн ирүүлсэн хүсэлт, шүүгч, прокурор, иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийн дагуу үүсгэж, шалгаж шийдвэрлэнэ.



47.2.Энэ хуулийн 47.1-д заасан хүсэлт, гомдол, мэдээлэлийг бичгээр ирүүлэх бөгөөд дараахь шаардлагыг хангасан тохиолдолд маргаан үүсгэх үндэслэл болно:

47.2.1.хүсэлт, гомдол, мэдээллийг ирүүлсэн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн нэр, холбоо барих мэдээлэл;

47.2.2.хүсэлт, гомдол, мэдээлэлд холбогдох өмгөөлөгчийн нэр, холбоо барих мэдээлэл, харьяалах өмгөөллийн хуулийн этгээдийн нэр, хаяг;

47.2.3.хууль, ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн талаархи мэдээлэл;

47.2.4.хууль, ёс зүйн дүрэм зөрчсөн гэж үзсэн үндэслэл, түүнийг нотлох баримт бичиг, мэдээ, мэдээлэл.

#### **48 дугаар зүйл.Маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа**

48.1.Нэг өмгөөлөгчид холбогдуулан хэд хэдэн хүсэлт, гомдол, мэдээлэл ирүүлсэн тохиолдолд Мэргэжлийн хариуцлагын хорооны даргын шийдвэрээр нэгтгэн нэг маргаан үүсгэж болох бөгөөд нэг өмгөөлөгчид холбогдуулан хэд хэдэн маргаан үүсгэсэн тохиолдолд Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрээр тэдгээрийг нэгтгэн хянан хэлэлцэж болно.

48.2.Мэргэжлийн хариуцлагын хороо маргааныг хянан шийдвэрлэхдээ доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

48.2.1.хүсэлт, гомдол, мэдээлэл ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн төлөөлөгч болон маргаанд холбогдох өмгөөлөгчөөс тайлбар авах;

48.2.2.хүсэлт, гомдол, мэдээлэлд дурдсан үйлдэл, эс үйлдэхүй, түүний шинж чанар, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал болон маргаанд ач холбогдолтой гэж үзсэн бусад нөхцөл байдлын талаар нэмэлт баримт, мэдээ, мэдээлэл цуглуулах;

48.2.3.хүсэлт, гомдол, мэдээлэлд дурдсан үйлдэл, эс үйлдэхүйн талаар мэдэх этгээдээс тайлбар авах;

48.2.4.тусгай мэдлэг шаардах асуудлаар мэргэжлийн байгууллага, шинжээч, мэргэжилтнээс тодорхойлолт, дүгнэлт гаргуулан авах.

48.3.Мэргэжлийн хариуцлагын хороо маргааныг хоёр сарын дотор хянаж, шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд Мэргэжлийн хариуцлагын хороо энэ зүйлд заасан хугацааг дахин нэг удаа хоёр хүртэл сарын хугацаагаар сунгаж болно.

48.4.Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх үед ёс зүйн маргааныг шалгах болон тухайн маргааныг шийдвэрлэх чиг үүрэг нь тус тусдаа байна.

48.5.Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх журмаар зохицуулна.

48.6.Мэргэжлийн хариуцлагын хороо энэ хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн хэрэг маргааны сан бүрдүүлж, хариуцлага хүлээлгэсэн өмгөөлөгчдийн бүртгэл хөтөлнө.

#### **49 дүгээр зүйл.Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэр**

49.1.Мэргэжлийн хариуцлагын хорооны хуралдаанд нийт гишүүдийн дийлэнх олонхи оролцсноор хүчин төгөлдөр болох бөгөөд шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргана.

49.2.Мэргэжлийн хариуцлагын хороо маргааныг хянаж, доор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргана:

49.2.1.өмгөөлөгч энэ хууль, Ёс зүйн дүрмийг зөрчсөн нь тогтоогдсон бол энэ хуулийн 44.3-т заасан хариуцлага хүлээлгэх;

49.2.2.өмгөөлөгч энэ хууль, Ёс зүйн дүрмийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй тогтоогдоогүй бол маргааныг хэрэгсэхгүй болгох;

49.2.3.маргааныг Хуульчдын холбооны ёс зүйн хороо хянан хэлэлцэж шийдвэрлэсэн шийдвэр нь хүчин төгөлдөр байгаа бол маргааныг хэрэгсэхгүй болгох;

49.2.4.энэ хуулийн 44.9-д заасан хариуцлага хүлээлгэх хугацаа өнгөрсөн бол маргааныг хэрэгсэхгүй болгох;

49.2.5.зөрчлийг тал бүрээс нь, бүрэн гүйцэт шалгаж тогтоогоогүй гэх үндэслэл байгаа бол нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах.

49.3.Энэ хуулийн 47.2.4-т заасан үндэслэлээр маргааныг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг өмгөөлөгч хүлээн зөвшөөрөөгүй бол маргааныг нийтлэг журмын дагуу хянан хэлэлцэж энэ хуулийн 49.2.1, 49.2.2-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.

49.4.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг Холбоо хариуцна.

#### **50 дугаар зүйл.Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрт гомдол гаргах**

50.1.Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэр албажиж гарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд өмгөөлөгч, эсхүл хүсэлт, гомдол, мэдээллийг ирүүлсэн этгээд шийдвэрийг эс зөвшөөрвөл гардан авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор захиргааны хэргийн **давж заалдах шатны** шүүхэд гомдол гаргах эрхтэй.

50.2.Энэ хуулийн 50.1-д заасны дагуу гомдлын дагуу шүүх маргаан хянан шийдвэр ажиллагааг эхлүүлсэн бол түүнийг эцэслэн хянан шийдвэрлэх хүртэл Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг биелүүлэхийг түдгэлзүүлнэ.

### **ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **51 дүгээр зүйл.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Холбоотой харилцах**

51.1.Хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийг хангах асуудлын хүрээнд Холбооноос явуулж байгаа үйл ажиллагаанд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэмжлэг үзүүлж, хяналт тавина.

51.2.Холбоо хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийн хэрэгжилттэй холбоотой тайлан, мэдээ, мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил тутам хүргүүлнэ.

51.3.Холбоо энэ хуульд заасан үйл ажиллагааны тайланг жил бүр, Их Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдааны талаархи тайланг тухай бүр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

51.4.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 51.1-д заасан хяналтыг тавихдаа Холбооны бие даасан байдалд нөлөөлөхийг хориглоно.

## **52 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

52.1.Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг